



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх”

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫГ ЗӨРЧСӨН ГЭРЭЭ
БАЙГУУЛСНААС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ 668.8 САЯ
ТӨГРӨГИЙН ХОХИРОЛ УЧИРСАН БАЙЖ БОЛЗОШГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: СБА-2023/12-16 НА-НА

Баруун-Урт 2023 он Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа
Утас: 70518396, Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа
Утас: 70512123, Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор С.Ариунбаяр
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг
Утас: 70512127, Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг	3
Дүрслэлийн товъёг.....	3
БҮЛЭГ 1. Улсын төсвөөс авах суурь зарлагыг илүү тооцсон, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн гэрээ байгуулснаас орон нутгийн төсөвт 668.8 сая төгрөгийн хохирол учирсан байж болзошгүй байна. ...	4
1.1 Төсвийн төслийг хууль, эрх зүйн актад заасан зарчим, шалгуурын дагуу боловсруулсан ч аймгийн ОНХС-аар хийгдэх төсөл арга хэмжээнд иргэдийн санал авахгүй байна.	4
Орон нутгийн төсвийн төслийг Сангийн яамны удирдамжийн дагуу боловсруулжээ.	4
Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн 86.2 хувийг сумдад олгожээ.....	5
Төсвийн тухай хууль зөрчиж төсөвт тодотгол хийжээ	6
БҮЛЭГ2: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн туслан гүйцэтгэгч илүү ажлын байрны төлбөр болон төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээний төлбөрийг барагдуулаагүй, Сангийн яам орон нутгийн төсөвт хуваарилах татварын орлогыг дутуу хуваарилсан, хууль тогтоомжийн дагуу татварын бааз суурийг нэмэгдүүлэх боломжтой байна.	8
2.1 Орон нутгийн татварын бааз суурийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийг орон нутагт төвлөрүүлснээр төсвийн орлого нэмэгдэх боломжтой байна.	8
Зарим нэр төрлийн татвар, төлбөр хураамж тасрах эрсдэлтэй байна.	8
Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагааны цар хүрээ ихэссэнтэй холбоотойгоор алдаа, зөрчлийн илрүүлэлт нэмэгджээ.....	13
2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн туслан гүйцэтгэгч илүү ажлын байрны төлбөр төлөөгүй, төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээний төлбөрийг бүрэн барагдуулаагүй, Сангийн яам орон нутгийн төсөвт хуваарилах татварын орлогыг дутуу хуваарилсан байна.	14
2.2.1 ААНОАТ-ыг цаг хугацаанд нь хуваарилаагүйгээс төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжих боломжгүй болжээ.	14
2.2.2 Ихэнх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн туслан гүйцэтгэгч илүү ажлын байрны төлбөр төлөхгүй байна.....	14
БҮЛЭГ3: Өмнөх онын аудитаар өгсөн санал, зөвлөмжийг 86.0 хувьтай хэрэгжүүлсэн ч хуулиар тогтоосон аймгийн чиг үүрэгт хамааралгүй, зураг төсөв батлагдаагүй ТЭЗҮ-гүй төсөл арга хэмжээг төлөвлөх зөрчил давтагдаж байна.	16
3.1 Урсгал зардлыг төлөвлөхдөө төрийн хэмнэлтийн хуульд нийцүүлэн төлөвлөсөн ч зураг төсөв, ТЭЗҮ-гүй төсөл арга хэмжээг төлөвлөх зөрчил давтагдаж байна.	16
3.1.1 Дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалтыг баталж хэрэгжүүлжээ.	16
3.1.2 Төсвийн урсгал зарлагыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн 628.6 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.....	17
Өмнөх онуудад худалдан авсан болон барьж байгуулсан зарим хөрөнгө зориулалтын дагуу ашиглагдахгүй байна.....	19
3.2 Аудитаар өгсөн зөвлөмж 86.1 хувьтай хэрэгжсэн бол, төсвийн орлого нэмэгдүүлэх, зардлын үр ашгийг дээшлүүлэх саналын 85.9 хувийг төсвийн төсөлд тусгасан байна.....	20
Өмнөх онд орлого нэмэгдүүлэх, зардлын үр ашгийг дээшлүүлэх саналыг төсвийн төсөлд тусгасан байна.	20
ДҮГНЭЛТ:.....	20
ЗӨВЛӨМЖ:.....	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн тайлбар

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТБӨЯХАТ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БТСГ	Биеийн тамир спортын газар
ГЗБТ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МЭГ	Мал эмнэлгийн газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
НА	Нийцлийн аудит
НА	Нотлох ажил
НД	Нийгмийн даатгал
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СБА	Сүхбаатар аймаг
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮХХХБОАТ	Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

№	Аймгийн 2024 оны төсвийн хязгаар	Хуудасны дугаар
1	Аймгийн 2024 оны төсвийн хязгаар	5
2	2023 оны төсөвт тодотгол хийсэн сумдын ИТХ-ын тогтоол	7
3	Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
4	Орон нутгийн 2024 оны төсвийн орлого	12
5	Татварын хяналт шалгалтын мэдээлэл	13
6	Уул уурхайн компаниудын орон нутгийн төсөвт төлсөн татварын мэдээлэл	15

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Аймгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	9

БҮЛЭГ 1. Улсын төсвөөс авах суурь зарлагыг илүү тооцсон, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн гэрээ байгуулснаас орон нутгийн төсөвт 668.8 сая төгрөгийн хохирол учирсан байж болзошгүй байна.

1.1 Төсвийн төслийг хууль, эрх зүйн актад заасан зарчим, шалгуурын дагуу боловсруулсан ч аймгийн ОНХС-аар хийгдэх төсөл арга хэмжээнд иргэдийн санал авахгүй байна.

Орон нутгийн төсвийн төслийг Сангийн яамны удирдамжийн дагуу боловсруулжээ.

1.1.1.1 Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/8472 албан бичгээр орон нутгийн төсвийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл удирдамжийг хүргүүлсэн байна.

1.1.1.2 Аймгийн Засаг дарга орон нутгийн 2024 оны төсвийн төслийг боловсруулан 2023 оны 11 сарын 23-ны өдрийн 01/1321 тоот албан бичгээр ирүүлсэн. Уг төсөлд орон хөрөнгө оруулалт, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтыг цуг ирүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1¹-т заасантай нийцэхгүй байгаа бөгөөд хуулийн хугацаанд дүгнэлт гаргахад хүндрэл үүсгэж байгаа тул цаашид анхаарах нь зүйтэй байна.

1.1.1.3 Аймгийн СТСХ-ээс 2024 оны жилийн төсвийн орлого зарлагыг 33,090.7 сая төгрөг байхаар тэнцвэржүүлэн төлөвлөжээ. Энэ нь 2023 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 7,320.3 сая төгрөг буюу 18.1 хувиар буурч төлөвлөсөн байна.

1.1.1.4 Аймгийн СТСХ-ээс орон нутгийн урсгал зардлыг хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж аймгийн орон нутгийн урсгал зардлыг дараах байдлаар нэмэгдүүлсэн байна Үүнд:

1. Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуульд хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр орон нутгийн чиг үүрэгт эрүүл мэндийн салбарын байгууллагын барилга, байгууламжийн ашиглалтын зардлыг хариуцахаар тусгасны дагуу 1,050.5 сая, Мөн шинээр спорт цогцолборын барилга ашиглалтад хүлээн авахтай холбоотой 388.1 сая төгрөгийг тус тус нэмэгдүүлжээ.
2. Засгийн газрын 2023 оны 312² дугаар тогтоолоор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Худалдан авах ажиллагааны газар байгуулахтай холбоотойгоор 333.4 сая төгрөгийг төлөвлөжээ.
3. Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд өөрчлөлт орж орон нутгийн нэмэгдлийг төрийн улс төрийн, төрийн үйлчилгээний албан тушаалтанд олгохоор заасан тул Засгийн газрын тогтоосон суурь хувиар тооцож төлөвлөсөн байна.
4. Тогтвортой амьжиргаа-3 төслийн хугацаа дуусаж байгаагаар холбоотойгоор аймгийн ЗДТГ-т 4 орон тоог нэмэгдүүлж, төсөлд тусгажээ.

1.1.1.5 Орон нутгийн төсвийн байгууллага болон тусгай шилжүүлгийн байгууллагын төсвийн төслийн саналыг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын нэгдүгээр³ хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.3.1-т заасан цагалбарт хугацаанд сумын Засаг даргад хүргүүлж, аймгийн Засаг даргад нэгтгэгдсэн байна.

¹ 8.5.1.аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

² “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын 5 дахь

³ Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам

1.2 Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор суурь зардлыг тооцоо судалгаагүй төлөвлөсөн, аймгийн Засаг дарга эрх хэмжээнээс давсан гэрээ байгуулж орон нутгийн төсөвт хохирол учруулсан байна.

Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн 86.2 хувийг сумдад олгожээ

1.2.1.1 Аймгийн СТСХ төсвийн суурь зарлагыг Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолын хавсралтаар⁴ батлагдсан аргачлалын 2.1⁵-т заасан ангиллын дагуу засаг захиргааны нэгж бүрээр нэгтгэн, 2024 оны төсвийн саналыг 64,018.2 сая төгрөгөөр тусган, Сангийн яаманд хүргүүлсэн.

1.2.1.2 Орон нутгийн 2024 оны суурь зарлагыг 2022 оны зардлын гүйцэтгэлээс 33,787.2 сая, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 27,371.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцож Сангийн яаманд хүргүүлсэн. Суурь зарлагыг өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тайлант оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээс нэмэгдүүлсэн талаар тодорхой тооцоо судалгаагүй төсвийн зардлыг төлөвлөсөн харагдаж байна. Тухайлбал:

- Аймгийн Засаг даргын ерөнхий дансаар дамжуулан үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь тодорхойгүй 3,285.7 сая;
- Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд 147.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь Баруун-Урт сумын ЗДТГ-ын төсөвт төсөлд давхардуулан тусгасан байна;

1.2.1.3 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3⁶-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн дээд хязгаарыг 32,381.3 сая төгрөгөөр баталжээ. Гэтэл 2024 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагыг хянасан дээд хязгаараас 1 дахин илүү буюу 64,018.3 сая төгрөгөөр хүргүүлжээ. Үүнээс үзэхэд төсвийн жилийн зарлагыг эдийн засгийн тооцоо судалгаагүй төлөвлөсөн нь харагдаж байна.

1.2.1.4 Төсвийн суурь зарлагыг тооцоо, судалгаагүй төлөвлөж Сангийн яаманд хүргүүлж байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсвийг үр ашигтай төлөвлөж, хэрэгжүүлэх зарчмыг хангаагүй, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилготой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2⁷, 6 дугаар зүйлийн 6.4.1⁸-т заасантай нийцэхгүй байна.

1.2.1.5 Засгийн газраас хянасан төсвийн хязгаарыг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний зарим төсөвт байгууллагын 2022 оны төсвийн гүйцэтгэлээс бага хэмжээтэй тооцож баталсан байна. Хүснэгт № 1

Код	Ангилал	2024 оны төсвийн хязгаар /сая төгрөгөөр/	2022 оны төсвийн гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Зөрүү
1200-00017	Сү. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	423.2	953.5	-530.3
1200-00019	Сү. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1,171.8	1,523.3	-351.5
1200-00023	Сү. Сумын Засаг даргын Тамгын газар	5,409.3	8,628.3	-3,219.0
1200-00437	Сү. Хот тохижуулах газар	1,148.0	1,690.5	-542.5
1200-00549	Сү. Ойн анги	60.3	243.2	-182.9
1200-10146	Сү. Аймгийн байгаль орчныг хамгаалах газар	702.7	839.1	-136.4
1200-10310	Сү. Санхүүгийн хяналт, аудитын алба	205.4	271.4	-66.0
1200-10754	Сү. Орон нутгийн өмчийн газар	210.8	252.7	-41.9

(Эх сурвалж: Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс)

⁴ Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал

⁵ Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг дараах байдлаар ангилна:

⁶ Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарыг дараах цаглаврын дагуу боловсруулж, батална.

⁷ төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;

⁸ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

1.2.1.6 Хүснэгтийн мэдээнээс үзэхэд зарим төсвийн байгууллагын төсвийн хязгаарыг өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс хэт багаар тооцож баталсан бөгөөд 2024 оны төсвийн саналд төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдэл, шатах тослох материал болон өргөн хэрэглээний бараа материалын үнийн өсөлт зэргээс шалтгаалан зарим төсөвт байгууллагын төсвийн зарлагыг засгийн газраас баталсан төсвийн хязгаараас нэмэгдүүлэн тооцохоос өөр аргагүй байна.

Төсвийн тухай хууль зөрчиж төсөвт тодотгол хийжээ

1.2.2.1 Аймгийн ИТХ-ын 2023 оны 3 сарын 31-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Аймгийн 2023 оны төсөв”-т өөрчлөлт оруулсан байна. Өөрчлөлтөөр төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 3,185.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2⁹-т заасныг зөрчсөн байна.

1.2.2.2 Төсвийн тодотголоор 1,073.5 сая төгрөгийн зардлыг шинээр нэмж баталсан байна. Үүнд:

1. Хүмүүнлэгийн зарим үйл ажиллагааг Улаан загалмайн хороогоор гүйцэтгүүлэхэд 350.0 сая;
2. Засаг даргын 2017 онд байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний үүргээ хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор Монголын Олон Улсын Арбитрын шийдвэрээр нөхөн төлбөрт олгох 273.5 сая;
3. Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жилийн зардалд 50.0 сая;
4. Хүүхдийн эрүүл мэндийн үзлэгт 100.0 сая;
5. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээлд 300.0 сая;

1.2.2.3 Харин Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой зардал 350.0 сая, гамшгаас хамгаалах зардлыг 210.0 сая, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой гарах зардлыг 83.2 сая, ХХОАТ-ын буцаан олголтыг 82.0 сая, удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг 1,075.0 сая, ОНХС-ийн зардлыг 308.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

1.2.2.4 Аймгийн 2023 оны 3 сарын 31-ны өдрийн тогтоолоор төсөвт өөрчлөлт оруулах танилцуулгад зарим шинээр нэмэгдсэн болон өмнөх тогтоолоос зардлыг нэмэгдүүлсэн талаарх тайлбар тодруулгыг тооцоо судалгаатай бүрэн гүйцэтгэж тусгаж илтгээгүй байна. Тухайлбал: хүмүүнлэгийн зарим ажлыг Улаан загалмайн хороогоор гүйцэтгүүлэх зардал, хүүхдийн хөгжлийг дэмжих болон эрүүл мэндийн үзлэгийн зардал, гамшгаас хамгаалах эрсдэлийн сан болон удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг нэмэгдүүлсэн талаар эдийн засгийн тооцоо судалгаатай танилцуулга бэлтгэж танилцуулаагүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2¹⁰-т заасантай нийцэхгүй байна.

1.2.2.5 Төсвийн тодотголоор болон нэмэгдүүлэн баталсан зардалд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах зардлыг баталсан дүнгээр зарцуулахгүй төсвийг хэмнэх, бусад шаардлагатай хөрөнгийн зардалд хуваарилж, төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх боломж байна. Үүнд:

1. Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуульд орон нутгаас тус нийгэмлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой төсвийг баталж гэрээ байгуулахаар тусгажээ. Уг заалтын хүрээнд төсвийн тодотголоор Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн төсөвт 350.0 сая төгрөгийг баталж, 250.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хүмүүнлэгийн тусламж үйлчилгээтэй холбоотой арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд

⁹ Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:

¹⁰ Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд уг арга хэмжээтэй холбогдуулан 2023 оны төсөвт 710.0 сая төгрөгийг баталсан байна. Иймд Улаан загалмайн нийгэмлэгээр дамжуулан зарцуулсан 250.0 сая төгрөгийн гүйлгээнд нарийвчилсан горим хэрэгжүүлж байна.

2. Төрийн зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхээр 533.2 сая төгрөг баталсан байна. Уг арга хэмжээний хүрээнд Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зарим чиг үүргийг зарим ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэх 2023 оны А/287 дугаар захирамж гаргажээ. Уг захирамжийн 9¹¹ дүгээр хавсралтаар арга хэмжээг хэрэгжүүлэхэд 188.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Иймд төрийн зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхээр тусгасан хөрөнгөнөөс 345.2 сая төгрөгийг хэмнэх боломжтой байна.

1.2.2.6 Аймгийн Засаг дарга, Ум тэнгэр трейд ХХК-ний хооронд 2017 оны 8 сард байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний хэрэгжилтэд маргаан үүсэж Монголын олон улсын арбитр орон нутгийн төсвөөс 668.8 сая төгрөгийг гаргуулах шийдвэр гарсан байна. Уг шийдвэртэй холбоотой нотлох баримтад дүн шинжилгээ хийж үзэхэд “Хөрөнгө оруулалтын гэрээ” нь хэт нэг талыг барьсан, орон нутагт ямар хөрөнгө оруулалт хийх нь тодорхойгүй, үр ашиггүй гэрээг байгуулсан байна. Иймд гэрээний маргаанаас үүссэн 668.8 сая төгрөгийн хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх, хууль эрх зүйн хүрээнд гэрээний үндсэн дээр байгуулагдсан Сүхбаатар проимпекс ХХК-ний үйлдвэрийн барилгыг орон нутгийн мэдэлд авах ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна.

1.2.2.7 Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор аймгийн ИТХ-ын 2023 оны 07 сарын 26 өдрийн 01 дүгээр тогтоолоор төсөвт өөрчлөлт оруулжээ. Тодотголоор төсвийн орлогыг 150.0 сая, ОНХНС-ийн орлогын шилжүүлгийг 3,451.7 сая, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,476.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

1.2.2.8 Дээд шатны төсөвт тодотгол хийсэнтэй холбоотойгоор сумд төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, ИТХ-аар батлуулсан байна. Сумын төсөвт тодотгол хийсэн байдлыг хүснэгтээр харуулав. Хүснэгт №2

д/д	Сумын нэр	төсөвт тодотгол хийсэн шийдвэрийн		Өөрчлөлт орсон мөнгөн дүн /сая төгрөгөөр/	
		огноо	дугаар	орлого	зарлага
1	Асгат	2023.8.11	1	43.5	309.5
2	Баруун-Урт	2023.8.02	18/03	631.6	930.1
3	Баяндэлгэр	2023.7.31	Б/38	(118.0)	195.2
4	Дарьганга	2023.7.31	А/01	36.6	297.8
5	Мөнххаан	2023.8.01	1	(356.6)	(73.9)
6	Наран	2023.7.31	А/01	10.0	303.7
7	Онгон	2023.7.31	5	45.0	301.5
8	Сүхбаатар	2023.8.01	А/23	8.5	1,122.1
9	Түвшинширээ	2023.8.10	3	8.0	240.5
10	Түмэнцогт	2023.8.01	01	35.0	275.7
11	Уулбаян	2023.8.02	5	20.6	193.2
12	Халзан	2023.8.01	1	19.5	242.7
13	Эрдэнэцагаан	2023.8.03	3	2,465.6	2,918.4
НИЙТ ДҮН				2,849.3	7,256.5

(Эх сурвалж: Сумдын ИТХ-ын төсөвт тодотгол хийсэн тогтоолын хуулбар)

¹¹ Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зарим арга хэмжээг ОНӨААТҮГ-уудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажил

1.2.2.9 Хүснэгтээс харахад татварын болон татварын бус орлогыг нийт дүнгээр 2,849.3 сая төгрөгөөр нэмж баталсан бөгөөд энэ нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор ХХОАТ-аас орох орлогыг нэмэгдүүлсэн нь нөлөөлжээ. Харин Эрдэнэцагаан сум Бичигтийн боомтод газрын дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотойгоор газрын төлбөрийн орлогыг 2,148.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь аймгийн хэмжээнд татварын орлого нэмэгдэхэд голлон нөлөөлжээ. Одоогийн байдлаар ГЗБТ-д тусгагдсан байршилд газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүйгээс уг орлого тасрах эрсдэл үүсжээ.

1.2.2.10 Харин Баяндэлгэр, Мөнххаан сумд төсвийн тодотголоор татварын болон татварын бус орлогыг 118.0-356.6 сая төгрөгөөр бууруулан баталжээ. Тухайлбал:

- Баяндэлгэр сум малын тоо толгойн албан татварыг өвөлжилт, хаваржилт хүндэрч малын зүй бус хорогдол их гарсантай холбоотойгоор 150.0 сая төгрөгөөр бууруулсан;
- Мөнххаан сум татварын бус орлогыг 261.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна. Энэ нь бусад орлого дансанд уул уурхай болон бусад эх үүсвэрээс төлөвлөөгүй орлого орох магадлалтай гэж үзэн тооцоо судалгаагүй хийсвэрээр орлогыг төлөвлөж батлуулсан нь нөлөөлж байна;

1.2.2.11 Хэдийгээр төсвийн тодотголоор татварын болон татварын бус орлого нь нийт дүнгээр нэмэгдсэн ч Баруун-Урт Дарьганга, Уулбаян сумын малын тоо, толгойн албан татварыг 5.4-52.2 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

1.2.2.12 Дээрх нөхцөл байдлаас дүгнэж үзэхэд зарим сум татварын орлогыг хэтэрхий өөдрөгөөр төсөөлж хэт их хэмжээгээр нэмэгдүүлэн баталсан, зарим сумд хууль тогтоомжид заасны дагуу төсвийн орлогыг төлөвлөж баталжээ.

1.2.2.12 Төсвийн орлогыг хэт өөдрөгөөр төсөөлөн батлуулсан нь жилийн эцэст төсвийн тодотгол хийх нөхцөл үүсэж, төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэхээр байна.

БҮЛЭГ2: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн туслан гүйцэтгэгч илүү ажлын байрны төлбөр болон төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээний төлбөрийг барагдуулаагүй, Сангийн яам орон нутгийн төсөвт хуваарилах татварын орлогыг дутуу хуваарилсан, хууль тогтоомжийн дагуу татварын бааз суурийг нэмэгдүүлэх боломжтой байна.

2.1 Орон нутгийн татварын бааз суурийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийг орон нутагт төвлөрүүлснээр төсвийн орлого нэмэгдэх боломжтой байна.

Зарим нэр төрлийн татвар, төлбөр хураамж тасрах эрсдэлтэй байна.

2.1.1.1 Аймгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг 10 сарын байдлаар авч үзэхэд нийт 12,991.1 сая төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэл 49.9 хувьтай хэрэгжиж байна. татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг дэлгэрэнгүйгээр харуулбал. Хүснэгт № 3

д/д	Татварын төрөл	Татварын болон татварын бус орлого /сая төгрөгөөр/		Гүйцэтгэлийн хувь
		төлөвлөгөө	гүйцэтгэл 11 сарын байдлаар	
1	ААНОАТ-ын 40 хувь	17,000.0	8,070.3	47.5
2	АТБӨЯХ-ийн албан татвар	590.0	611.3	103.6

3	Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөр	520.0	686.1	131.9
4	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	59.2	
5	ХХОАТ /суутган-1/	-	109.9	
6	Газрын дуудлага худалдааны орлого	4,000.0	680.4	17.0
7	Улсын тэмдэгтийн хураамж	-	81.1	
8	Төрийн өмч худалдан борлуулсны орлого	50.0	9.1	18.2
9	Зам ашигласны төлбөр	-	45.7	
10	Хүү торгуулийн орлого	600.0	729.1	121.5
11	Бусад орлого	3,300.0	1,908.9	57.8
НИЙТ ДҮН		26,060.0	12,991.1	49.9

(Эх сурвалж: Татварын хэлтсийн орлогын 10 сарын мэдээ, холбогдох дансны хуулга)

2.1.1.2 Аймгийн татварын болон татварын бус орлогын дэлгэрэнгүй мэдээнээс харахад нийт төлөвлөсөн орлогын 65.2 хувийг ААНОАТ эзэлж байгаа бөгөөд одоогоор хэрэгжилт 47.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь хангалтгүй байна. Энэ нь Сангийн яамнаас тус татварын орлогын орон нутгийн төсөвт ногдох хэсгийг цаг хугацаанд нь хуваарилахгүй байгаагаар холбоотой байна.

2.1.1.3 Харин бусад төлөвлөсөн орлогоос газрын дуудлага худалдаанаас орох орлого 3,319.6 сая, бусад орлого /уул уурхайн аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээний төлбөр/ 1,391.1 сая төгрөгөөр тасрах эрсдэл үүсэж байна.

2.1.1.4 Газрын дуудлага худалдаанаас орох орлогын дуудлага худалгааг яаралтай зохион байгуулж, орлогыг бүрдүүлэх талаар анхаарахгүй бол төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

2.1.1.5 Аймгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг 2019-2022 оны байдлаар харьцуулж үзэхэд: График № 1



2.1.1.7 Графикаас харахад орон нутгийн төсвийн орлого 2019-2020 онд 24.4-474.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь тухайн жилүүдэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгасан төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүйтэй холбоотой байна. Харин 2021-2022 онд төсвийн орлого 8.5-48.7 хувиар давж биелжээ. Төсвийн орлого давж биелэхэд 2021 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, зарим төрийн албан хаагчийн цалин нэмэгдсэнээс ХХОАТ-ын орлого 1,122.3 сая төгрөгөөр давсан нь нөлөөлжээ. 2022 онд төсвийн орлого 6,139.4 сая төгрөгөөр давж биелэхэд төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж ААНОАТ-ын зохих хувийг орон нутгийн төсөвт хуваарилдаг болсон нь голлон нөлөөлж байна.

2.1.1.8 Мөн төсвийн орлогын нэр төрөл тус бүрээр дүн шинжилгээ хийж үзэхэд дараах татвар жил бүр дараах байдлаар төлөвлөгөөнөөс давж биелсэн байна. Үүнд:

1. Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар 7.9-20.7 хувиар;
2. Ус рашааны нөөц ашигласны төлбөр 11.3-49.2 хувиар тус тус давжээ;

2.1.1.9 Газрын төлбөр 2021-2022 онд газрын төлбөр их хэмжээгээр давж биелж байгаа газрын дуудлага худалдаанаас орсон орлогыг газрын төлбөрийн дансанд төвлөрүүлж байгаа нь нөлөөлжээ.

2.1.3.10 Орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар төр захиргааны байгууллагаас холбогдох арга хэмжээг авч ажилласан эсэхэд дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр: Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.21¹²-т заасны дагуу малын гарал үүслийн тодорхойлолтын хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхгүйгээр тойргийн малын эрүүл мэндийг хариуцаж байгаа хувийн мал эмнэлгүүдийн орлого болжээ. Эрх бүхий байгууллага албан тушаалтнаас малын гарал үүслийн тодорхойлолтын төлбөрийг хувийн мал эмнэлгийн орлого болгох талаар гаргасан шийдвэргүй байна. Энэ нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3¹³-т заасныг зөрчиж байна.

Мал эмнэлгийн газраас аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мал нядалгаа, мах боловсруулах үйлдвэрлэлд оруулсан болон үржил, отор нүүдлийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гарал үүслийн тодорхойлолт гаргуулсан малын тоог төрөл тус бүрээр авч дүн шинжилгээ хийх үзэхэд 2023 оны 11 сарын байдлаар 219.6 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрөх тооцоо гарч байна. Иймд малын гарал үүслийн тодорхойлолтын төлбөрийг орон нутгийн орлого болгох, хууль эрх зүйн хүрээнд өөрчлөлт оруулах, журам шинэчлэн боловсруулж шийдвэрлүүлэх шаардлага үүссэн байна.

Мөн хуулийн 39¹⁴ дүгээр зүйлд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгохтой холбоотойгоор тэмдэгтийн хураамжийг хэмжээг тогтоож өгчээ. Гэтэл аймгийн ГХБХБГ-аас газар олгох зөвшөөрлийн гэрчилгээ цахимд шилжсэнтэй холбоотойгоор уг төрлийн тэмдэгтийн хураамжийг авч төсөвт төвлөрүүлээгүй байна. Аймгийн Засаг даргын шийдвэрээр 2022-2023 онд гарсан газар өмчлөх, ашиглах, эзэмшихтэй холбоотой гарсан шийдвэрээс үзэхэд тэмдэгтийн хураамжийн төлбөрийн орлого 2.8 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрөхөөр харагдаж байна. Үүнийг аймгийн хэмжээгээр тооцож үзэхэд жилд дунджаар 10.0 сая төгрөг төвлөрөх боломжтой байна.

Иймд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгохдоо Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т заасан хэмжээгээр тооцон төлбөр авч орон нутгийн төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй байна.

Ус рашаан ашигласны төлбөр: Уул уурхайн аж ахуйн нэгж, байгууллагын хөрсний усыг үйлдвэрлэлд ашиглах болон шавхан зайлуулахтай холбоотойгоор дараах зөрчил илэрлээ. Үүнд:

¹² малын удам гарвалийн болон эрүүл мэндийн гэрчилгээ, шилжилт хөдөлгөөний тодорхойлолт, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх итгэмжлэлийн гэрчилгээ, мал, үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ олгоход 2000-10 000 төгрөг.

¹³ Тэмдэгтийн хураамжийн орлогыг улсын болон орон нутгийн төсвийн дансанд тушаах бөгөөд бэлнээр хураасан орлогын хэмжээ 10 000 төгрөг хүрсэн тухай бүрд дансанд тушааж байна.

¹⁴ Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох, газрын хэвлийг олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

1. Эрдэнийн олз ХХК нь уурхайн карьерт үүссэн хөрсний усны хэмжээг Жи Эн Эн Эс Суврэй ХХК-аар тогтоолгон 153,323 м³ усыг Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргааны шийдвэр гаргуулан төлбөр төлөхгүйгээр шавхан зайлуулсанд 119.1 сая;
2. Цайрт минерал ХХК зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр төлөөгүйгээс төсөвт 8.6 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн;

Дээрх зөрчил Усны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1¹⁵, 31.2¹⁶, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6¹⁷ дугаар зүйлийн 6.1.2¹⁸, Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмыг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоосон.

Мөн Эрээн толгой ХХК, Монгол жүюаньли ХХК нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан болон шавхан зайлуулж, зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг хууль тогтоомжид заасны дагуу шатлан өсгөх хэлбэрээр төлөөгүй байх эрсдэл үүссэн тул аймгийн Татварын хэлтэст зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

Үл хөдлөх, эд хөрөнгийн албан татвар: Улсын бүртгэлийн хэлтсээс 2020-2023 онд үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ашиглалтад орсон барилга байгууламжийн судалгаагаар 113 иргэн, хуулийн этгээд 14,215.5 сая төгрөгийн үнэлгээтэй эд хөрөнгийг бүртгүүлсэн байна. Улсын бүртгэлд бүртгэгдсэн үнэлгээгээр аймгийн ИТХ-аар баталсан хувь хэмжээгээр татвар ногдуулахад орон нутгийн төсөвт 142.1 сая төгрөг төвлөрөх боломжтой байна. Татварын хэлтэстэй хийсэн тулган баталгаажуулалтаар дээрх үл хөдлөх хөрөнгөд татвар ногдуулаагүй байна.

Аймгийн хэмжээнд уул уурхайн ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Цайрт минерал, Талын гал, Монгол жүюаньли, Эм эл цахиурт овоо, Хунт өгөөж зэрэг аж ахуйн нэгжүүдээс бусад нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар барьж ашиглаж байгаа барилга байгууламжид үл хөдлөх хөрөнгийн албан татварыг төлөхгүй байна.

Дээрх зөрчлүүд нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2¹⁹, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4²⁰ дүгээр зүйлийн 4.1.1²¹, 6 дугаар зүйлийн 6.1²²-т заасныг зөрчсөнд зөрчлийг арилгуулах албан шаардлагыг Татварын хэлтэст хүргүүлээ.

Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар: Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа АТӨЯХАТ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1²³-т том оврын механизмд татвар ногдуулахаар тусгаагүй, зөвхөн тусгай зориулалтын авто машинд ногдуулахаар тусгасан байна. Үүнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын тогтоолоор том оврын механизмд 22,000 төгрөгийн татвар ногдуулж байна. Иймд уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг УАГ-т хүргүүлээ.

¹⁵ Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө.

¹⁶ Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлөх бөгөөд шатлан өсгөх хэлбэрээр төлбөр тооцох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

¹⁷ Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

¹⁸ уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус

¹⁹ Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

²⁰ Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа дараах этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна:

²¹ өмчийн бүх төрөлд хамаарагдах компани, хоршоо, нөхөрлөл, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төлөөлөгчийн газар;

²² Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-2.0 хувиар тооцож ногдуулна.

²³ Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг дараах хэмжээгээр ногдуулна.

Аудитын явцад хийсэн дүн шинжилгээ, тооцоо судалгаанаас харахад дээрх татвар төлбөр хураамжийн бааз суурийг нэмэгдүүлэн жилийн төсвийн орлогыг нэмж төлөвлөх боломж байна гэж үзлээ.

Орон нутгийн 2024 оны жилийн төсвийн орлогын талаар:

Орон нутгийн 2024 оны жилийн төсвийн татварын болон татварын бус орлогыг 21,275.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Татварын болон татварын бус орлогыг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд баталсан орлого, аймгийн орлогын санал, 2023 оны 10 сарын байдлаарх орлогын гүйцэтгэлийн харьцуулж харуулбал. Хүснэгт № 4

д/д	Татварын төрөл	2023 оны гүйцэтгэл 10 байдлаар	Татварын болон татварын бус орлого /сая төгрөгөөр/	
			УИХ-аар баталсан	Аймгийн санал
1	ААНОАТ-ын 40 хувь	8,070.3	15,000.0	15,000.0
2	АТБӨЯХ-ийн албан татвар	611.3	600.0	600.0
3	Үйлдвэрлэлд ашигласан усны төлбөр	686.1	600.0	600.0
4	Газрын дуудлага худалдааны орлого	680.4	-	1,000.0
5	Төрийн өмч худалдан борлуулсны орлого	9.1		50.0
6	Зам ашигласны төлбөр	45.7	-	-
7	Хүү торгуулийн орлого	729.1	700.0	600.0
8	Төсөвт байгууллагын өөрийн орлого	15.0	51.8	15.0
9	Бусад орлого /хилийн/	800.0		300.0
10	Сумаас төвлөрүүлэх орлого			610.4
11	Хандив тусламжийн орлого	1,908.9		2,500.0
	НИЙТ ДҮН	10,832.0	16,951.8	21,275.4

Аймгийн 2024 оны жилийн төсвийн орлогын төлөвлөгөө, 2023 оны орлогын гүйцэтгэл, аудитаар олж авсан зарим нотлох зүйлд үндэслэн дараах төрлийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна гэж үзлээ. Үүнд:

- 1. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр:**
Харьяалах усны сав газраар дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авсан үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглаж байгаа 2, хөрсний ус шавхан зайлуулж байгаа 6 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж ажиллаж байна. Цайрт минерал ХХК нь үйлдвэрлэлийн зориулалтаар сүүлийн 5 жилийн дунджаар 318,975 м³, шавхан зайлуулсан 35,000 м³ ус ашиглажээ. Дээрх тооцоололд үндэслэн ашигласан усны төлбөрийг экологи, эдийн засгийн үнэлгээгээр тооцоход ус уурхайгаас үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрт 743.5 сая, шавхан зайлуулсан усны төлбөрт 31.8 сая төгрөг тус тус төвлөрөхөөр байна. Нүүрс болон хайлуур жоншны олборлолт эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдээс Монгол жүюаньли ХХК үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрт сүүлийн таван жилд 254.7 сая төгрөг төвлөрүүлсэн бөгөөд харьцуулсан дүн шинжилгээ хийсэн онуудаас хамгийн бага төлөлтөөр тооцож үзэхэд 32.4 сая, Хунт өгөөж ХХК сүүлийн таван жилийн дунджаар 13.6 сая төгрөг тус тус төвлөрүүлэх тооцоо гарч байна. Эрдэнэцагаан, Сүхбаатар сумын нутагт нүүрсний олборлолт явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн усны дүгнэлтээс үзэхэд жилд дунджаар 150.0-200.0 сая төгрөг төвлөрөх тооцоо гарч байна. Дээрх тооцооллоос үзэхэд усны төлбөрт 971.3 сая төгрөг тооцоо гарч байгаа тул төсвийн орлогыг 371.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.
- 2. АТӨЯХАТ:** Уг татварын 2023 оны гүйцэтгэлээс харахад 611.3 сая төгрөг төвлөрчээ. Мөн 2023 оны 9 сарын байдлаар 1,159 тээврийн хэрэгсэл шинээр

нэмэгдсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор 15.0 сая төгрөгийн орлого нэмэгдэх боломжтой байна.

3. **Зам ашигласны төлбөр:** 2023 оны 10 сарын байдлаар зам ашигласны төлбөр хураамжаас 45.7 сая төгрөгийн орлого төвлөрчээ. Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-т авто зам ашигласны төлбөрийн хэмжээг аймгийн ИТХ-аар тогтоохоор заажээ. Аймгийн ИТХ-ын “,” тогтоолоор баталсан төлбөрийн хэмжээ, 2023 онд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто тээврийн хэрэгслийн тоо зэрэгт үндэслэн зам ашигласны төлбөрийн хэмжээг тооцож үзэхэд 71.4 сая төгрөг төвлөрөх тооцоо гарч байна.

Сумын төсөвт төвлөрөх ХХОАТ-ын тооцооллыг төрийн албан хаагчийн албан тушаалын цалин, нэмэгдэл зэргийг дунджаар тооцон үзэхэд нийт дүнгээр 571.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна.

Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагааны цар хүрээ ихэссэнтэй холбоотойгоор алдаа, зөрчлийн илрүүлэлт нэмэгджээ.

2.1.3.1 Аймгийн татварын хэлтэс нь Татварын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.4.3²⁴-т заасны дагуу эрсдэлд үндэслэн хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

2.1.3.2 Тус хэлтсээс 2020-2023 оны 10 сарын байдлаар давхардсан тоогоор 94 хуулийн этгээдийг татварын хяналт шалгалтад хамруулж 9,231.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, хууль тогтоомжид заасны дагуу нөхөн ногдуулалтын 879.0 сая төгрөгийн акт тогтоож, 160.4 сая төгрөгийн алданги тооцсон бол иргэн, хуулийн этгээдэд 317.1 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. Татварын хяналт шалгалтын мэдээг он тус бүрээр харуулбал Хүснэгт № 5

он	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо	Илэрсэн зөрчлийн мөнгөн дүн /сая.төг/	Хяналт шалгалтаас гарсан шийдвэрийн мөнгөн дүн /сая.төг/		
			нөхөн ногдуулсан акт	Алданги	Торгууль
2020	30	514.9	48.0	8.5	16.6
2021	35	2,531.9	217.3	30.2	70.1
2022	14	827.7	80.3	16.6	29.7
2023	15	5,357.0	533.4	105.1	200.7
НИЙТ ДҮН	94	9,231.5	879.0	160.4	317.1

(Эх сурвалж: Татварын хяналт шалгалтын мэдээ)

2.1.3.3 Хүснэгтээс харахад 2023 оны 10 сарын байдлаар хэрэгжүүлээд байгаа хяналт шалгалтаар илэрсэн зөрчил өмнөх онуудаас 2-10 дахин нэмэгдсэн байна. Энэ нь шалгалтад хамрагдсан байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, борлуулалтын орлого, зардлын гүйлгээ их (уул уурхайн компани гэх мэт), хяналт шалгалт хэрэгжүүлж байгаа байцаагчийн мэдлэг, ур, чадвар өссөн, салбар хуулиудад өөрчлөлт орсон зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

²⁴ эрсдэлийг үнэлэх, шинжлэх;

2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн туслан гүйцэтгэгч илүү ажлын байрны төлбөр төлөөгүй, төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээний төлбөрийг бүрэн барагдуулаагүй, Сангийн яам орон нутгийн төсөвт хуваарилах татварын орлогыг дутуу хуваарилсан байна.

2.2.1 ААНОАТ-ыг цаг хугацаанд нь хуваарилаагүйгээс төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжих боломжгүй болжээ.

2.2.1.1 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-т аймгийн татварын орлогод ААНОАТ-ын 40 хувийг олгохоор заасан байна. Сангийн яамнаас ААНОАТ-ыг хуваарилсан байдлыг авч үзвэл 2022 онд нийт 13,820.4 сая төгрөг хуваарилснаас 9,637.2 сая төгрөгийг аймгийн төсвийн орлогын дансанд, 4,183.2 сая төгрөгийг Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн урт хугацаат зээлийн өр төлбөрт суутган тооцсон байна.

2.2.1.2 Тайлант онд Цайрт минерал ХХК нь ААНОАТ-т 45,217.9 сая төгрөг төлсөн бөгөөд төсвийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож үзэхэд орон нутгийн төсөвт 18,087.1 сая төгрөг хуваарилагдах тооцоо гарч байна. Уг тооцоололд үндэслэн үзэхэд Сангийн яам орон нутгийн төсөвт төвлөрөх 4,266.7 сая төгрөг буюу 23.5 хувийг дутуу хуваарилсан харагдаж байна.

2.2.1.3 Харин 2023 оны 3-р улирлын байдлаар авч үзэхэд Сангийн яамнаас 8,070.3 сая төгрөгийг хуваарилжээ. Тайлант оны 3-р улирлын байдлаар ААНОАТ төлсөн байдлыг авч үзэхэд Цайрт минерал ХХК 31,643.1 сая, Нагааранз ХХК 108.9 сая, бусад жижиг татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллага 303.3 сая төгрөгийг төлсөн байна. Уг төлөлтөөр тооцоо хийж үзэхэд 2023 оны 3-р улирлын байдлаар төлсөн ААНОАТ-аас 12,822.1 сая төгрөгийг хуваарилахаар байгаа бөгөөд 4,751.8 сая төгрөг дутуу хуваарилагдсан байна.

2.2.1.4 Сангийн яамнаас ААНОАТ-ын орон нутгийн төсөвт ногдох хэсгийг дутуу хуваарилсантай холбоотойгоор ҮАГ-т уламжлан шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлээд байна.

2.2.1.5 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10²⁵-т заасныг зөрчиж ААНОАТ-ыг цаг тухай бүрд нь хуваарилахгүй байгаа нь орон нутаг бие даан хөгжих, жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, төсөвт дахин тодотгол хийх нөхцөл үүсээд байна.

2.2.1.6 Мөн Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Хунт өгөөж ХХК нь 2022-2023 онд тус төрлийн татварт 201.5 сая төгрөг төлсөн боловч 40 хувь болох 80.6 сая төгрөгийг аж ахуйн нэгжийн бүртгэл үүссэн Хэнтий аймгийн төсөвт хуваарилагдаж байна.

2.2.1.7 Цаашид аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа жигдэрч борлуулалт нэмэгдсэнээр аймаг улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахгүйгээр санхүүгийн эх үүсвэрийг дотоод нөөц бололцоогоор бүрдүүлэх бүрэн боломж харагдаж байна.

2.2.2 Ихэнх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн туслан гүйцэтгэгч илүү ажлын байрны төлбөр төлөхгүй байна

2.2.2.1 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас дараах аж ахуйн нэгж Төсвийн тухай хуульд заасан орон нутгийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогыг төвлөрүүлж байна. Хүснэгт№ 6

²⁵ аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь.

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Орон нутгийн төсөвт төлсөн татварын мөнгөн дүн /сая төгрөгөөр/				
		2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Цайрт минерал ХХК	1,584.6	1,488.9	1,864.9	2,082.2	1,989.3
2	Монгол жүюаньли ХХК	863.5	134.9	82.5	555.0	28.5
3	Хунт өгөөж ХХК	12.5	19.6	24.6	30.0	29.3
4	Эм Эл Цахиурт овоо ХХК	110.6	111.6	276.1	127.1	69.9
5	Талын гал ХХК	118.2	174.1	207.6	51.9	42.3
6	Нагааранз ХХК	6.4	27.1	0.9	0.7	35.0
7	Эрээн толгой ХХК	-	-	-	145.8	32.8
ДҮН		2,695.8	1,956.2	2,456.6	2,992.7	2,227.1

2.2.2.2 Аймгийн нутагт дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагатай Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1²⁶-т заасны дагуу ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Гэрээнд тусгасан 2021-2023 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлбэл зохих 1,219.2 сая төгрөгийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн 6 тусгай зөвшөөрөл эзэмшигчид “Байгаль орчин, уул уурхайн нөхөн сэргээлтийн үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар акт тогтоосон.

2.2.2.3 Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулган зохион байгуулахтай холбоотойгоор 2023 оны хамтран ажиллах гэрээнд тусгайлан заалт оруулан 10.0-20.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр тусгаж уг заалтын хүрээнд Нүүдэлчдийн агуулга НҮТББ-ийн дансанд 138.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.2.2.4 Уг чуулга уулзалтыг зохион байгуулахтай холбоотойгоор Цайрт минерал ХХК-аас шууд дамжуулалтын зардалд 60.0 сая төгрөгийг Датукон (BBS телевиз) ХХК, зочид төлөөлөгчдийг хүлээн авах зардалд 54.6 сая төгрөгийг Дарьганга катеринг ХХК-ийн дансанд тус тус шилжүүлсэн байна.

2.2.2.5 Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн гадаад ажилчдын мэдээллийг ГИХГ-аас авч нийгмийн даатгалын шимтгэлийн НД-7, НД-8 тайланд үндэслэн ажиллах хүчний харьцаанаас илүү ажлын байрны төлбөрийг тооцож үзэхэд Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2²⁷-т заасны дагуу илүү гарсан ажлын байр тутамд төлбөр төлөөгүй, дутуу төлсөн зөрчил илэрсэн. Үүнд:

- Үйлдвэрлэлийн барилга байгууламжийн корпораци ХХК 2022 онд 41 гадаад ажилтны 172.2 сая төгрөг дутуу;
- Ай ЭМ Жи Эф индистраил энд майнинг ХХК 2022, 2023 оны эхний 6 сарын байдлаар 68 гадаад ажилтны 310.3 сая төгрөг дутуу;
- Тэргүүн нандин хөрс ХХК 2023 оны 21 гадаад ажилтны ажлын байрын төлбөр 115.5 сая төгрөгийг огт төлөөгүй байна.;

Иймд ажиллах хүчний харьцаанаас илүү гарсан ажлын байр тутамд төлбөл зохих нийт 598.0 сая төгрөгт төлбөрийн акт тогтоосон.

²⁶ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана

²⁷ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 43.1.1-д зааснаас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, 43.1.2-т зааснаас бага хэмжээгээр орон нутгийн иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.

2.2.2.6 Эрдэнэцагаан сумын нутагт нүүрсний олборлолт явуулж байгаа Бадмаараг хаш ХХК-тай хамтран ажиллах гэрээтэй Паринтес ХХК-ний туслан гүйцэтгэгч /хөрс хуулах/ Газар хорвоо ХХК өөрийн нэр дээр 2023 оны 6 сард БНХАУ-ын 14 иргэнийг уул уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлүүлэхээр оруулж ирсэн боловч ажиллах хүчний харьцааны төлбөр 280.0 сая төгрөгийг төлөхгүйгээр гэрээний хугацаа дуусаж уг ажилчдыг буцаасан зөрчил илэрсэн. Иймд уг төлбөрийг төлүүлэх нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж байна.

2.2.2.7 Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.2²⁸-т монгол ажилчдын 5-аас доошгүй хувийг тухайн сумын иргэд байхаар тусгасан бөгөөд ихэнх тусгай зөвшөөрөл эзэмшигч уг заалтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь тухайн суманд уул уурхайн салбарт шаардлагатай мэргэжил эзэмшсэн иргэн байхгүйгээс зөвхөн туслах ажилтнаар авдаг ч тогтвор суурьшилтай ажиллахгүй байна. Иймд тухай орон нутгийн иргэдийг хүнд даацын машин, механизмын операторын сургалтад хамруулж, тогтмол ажлын байраар хангах талаар хамтран ажиллах гэрээнд тусган ажиллах зүйтэй байна.

2.2.2.9 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд ихэнх нь Улаанбаатар хотын харьяалалтай аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд уг туслан гүйцэтгэгч компанийн төлсөн татварын орлого тухайн орон нутгийн төсөвт төвлөрөхгүй байна.

2.2.2.10 Дээрх байдлаас дүгнэж үзэхэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагууд Төсвийн тухай хуульд заасан орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх, харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн хүүхдийн сургалтын төлбөрийг төлөхөөс бусдаар үр өгөөж өгч чадахгүй байна.

БҮЛЭГЗ: Өмнөх онын аудитаар өгсөн санал, зөвлөмжийг 86.0 хувьтай хэрэгжүүлсэн ч хуулиар тогтоосон аймгийн чиг үүрэгт хамааралгүй, зураг төсөв батлагдаагүй ТЭЗҮ-гүй төсөл арга хэмжээг төлөвлөх зөрчил давтагдаж байна.

3.1 Урсгал зардлыг төлөвлөхдөө төрийн хэмнэлтийн хуульд нийцүүлэн төлөвлөсөн ч зураг төсөв, ТЭЗҮ-гүй төсөл арга хэмжээг төлөвлөх зөрчил давтагдаж байна.

3.1.1 Дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалтыг баталж хэрэгжүүлжээ.

3.1.1.1 Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 сарын 10-ны өдрийн 03 дугаар тогтоолоор "Сүхбаатар аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг 04 тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлуулахтай хамтатган үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулжээ.

3.1.1.2 Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа зарим хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгийн хэмжээ тодорхойгүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.3²⁹-т заасантай нийцэхгүй байна.

3.1.1.3 Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр 2022-2023 онд санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалтаар батлагдсан төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад тусгагдсан эсэхийг тулган баталгаажуулахад зарим арга хэмжээ хөтөлбөрт тусгагдаагүй байна. Үүнд

²⁸ Монгол ажилтнуудын 5-аас доошгүй хувь нь уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа тухайн сум, дүүргийн иргэд байх.

²⁹ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:

- Удирдлагыг хэрэгжүүлэх зардлын төсөл арга хэмжээний жагсаалтад 3,928.7 сая төгрөгийн 8 арга хэмжээ;
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалтад 3,626.6 сая төгрөгийн 12 арга хэмжээг баталсан байна.

3.1.1.4 Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4³⁰-т заасныг зөрчиж байна.

3.1.1.5 Мөн аймгийн ЗДТГ-ын барилгын их засварын ажил төсөл арга хэмжээг 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалтад 17.4 сая, их засварын зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад 56.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр давхардуулан баталсан байна.

3.1.1.7 Иймд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний жагсаалтад батлагдсан арга хэмжээг санхүүжүүлж байх нь зүйтэй байна.

3.1.2 Төсвийн урсгал зарлагыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн 628.6 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.

Аймгийн Засаг даргын ирүүлсэн төсвийн зарлагыг, байгууллага, арга хэмжээ тус бүрээр давтан тооцоолол хийж үзэхэд дараах зардлыг хэмнэх боломжтой байна.

3.1.2.1 Аймгийн ИТХ-ын даргын нөөц сангийн зарцуулалтад 120.0 сая төгрөгийг төлөвлөсөн бөгөөд нөөц сан зарцуулах журам нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-тай ижил байна. Мөн Захиргааны хэм хэмжээний акт нь улсын бүртгэлд бүртгэснээр хүчин төгөлдөр болох бөгөөд хуулийн хүчин төгөлдөр бус хэм хэмжээний актаар төсөв захиран зарцуулж байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4³¹ дэх, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5³²-т заасныг зөрчиж байна. Иймд нөөц санд зарцуулахаар төлөвлөсөн дээрх хөрөнгийг хасаж тооцох нь зүйтэй байна.

3.1.2.2 Арбитрын 2021 оны 10сарын 29-ны өдрийн 680 дугаар шийдвэрээр орон нутгийн төсвөөс Ум тэнгэр трейд ХХК-д 668.8 сая төгрөгийг олгохоор болсон бөгөөд 2023 онд төсвөөс 273.5 сая, орон нутгаас олгосон хөнгөлөлттэй зээлийн төлбөрийн үлдэгдлээс 245.3 сая төгрөгийн өр төлбөрийн чөлөөлсөн байна. Гэтэл төсвийн төсөлд төсвөөс 395.3 сая төгрөгийг төлөхөөр төлөвлөжээ. Иймд зээл төлбөрөөс зээлсэн дүнг хасаж тооцооноор тус компанид 158.0 сая төгрөг төлөх тооцоо гарч байгаа тул 237.3 сая төгрөгийг хасаж тооцох нь зүйтэй байна.

3.1.2.3 Баруун-Урт сумын ИТХ Засгийн газрын 2021 оны 376³³ тогтоолоор баталсан орон тооноос илүү орон тоотойгоор төсвийн төслийг төлөвлөсөн байна. Уг тогтоолын 2-т (аймгийн төвийн болон 6000-аас дээш хүн амтай)-ын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг 4 хүртэл) байхаар тусгасан байхад одоогоор 6 орон тоогоор төсөвлөсөн байна. Засгийн газрын тогтоол үндэслэн тооцож үзэхэд 30.2 сая төгрөгийн зардлыг хэмнэх боломжтой байна. Сумын ИТХ болон нэг цэгийн үйлчилгээний албан хаагчдын 2024 оны 4 сарын 1-ны өдрөөрх цалингийн нэмэгдлийг

³⁰ эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;

³¹ Захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ.

³² бусад тусгай сангийн үйл ажиллагаатай давхардаагүй байх;

³³ Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай

тооцохдоо бүтэн жилээр тооцсон бөгөөд цалин нэмэгдэх хугацаанаас буюу 9 сараар тооцож үзэхэд 137.1 сая төгрөгийг илүү төлөвлөсөн байна.

3.1.2.4 Аймгийн ЗДТГ-ийн албан хаагчдын цалинг давтан тооцоолж үзэхэд цэргийн штабын (төрийн тусгай) албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгохоор төлөвлөсөн бөгөөд уг нэмэгдлийг төрийн тусгай албан хаагчид олгох талаар хууль, эрх зүйн актад тусгагдаагүй нэмэгдлийг олгохоор тооцсоноос 34.3 сая төгрөг хэмнэгдэх боломжтой байна. Мөн зарим мэргэжилтэнд хууль, тогтоомжид тусгайлан заагдаагүй ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгохоор тусгаж 29.7 сая төгрөгийн нэмэгдэл олгохоор төлөвлөсөн байна.

3.1.2.5 Асгат, Баяндэлгэр, Дарьганга сумын ЗДТГ-ын цалин, нэмэгдлийг тооцохдоо 40.0 сая төгрөгийн урамшууллыг давхардуулан тооцсон байна.

Иймд төсвийн тооцоолол оруулсан дээрх 628.6 сая төгрөгийг орон нутгийн төсвийн төслийн урсгал зардлаас хасаж тооцох нь зүйтэй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын талаар:

3.1.2.7 Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр шинээр 27 төсөл арга хэмжээг 8,998.2 сая, авто замын сангийн хөрөнгөөр 1 төсөл арга хэмжээг 600.0 сая, их засварын зардлаар 8 төсөл арга хэмжээг 2,000.6 сая, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 8 төсөл арга хэмжээг 477.6 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.1.2.8 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих 3 төсөл, арга хэмжээ орон нутгийн чиг үүрэгт нийцээгүй, ТЭЗҮ, зураг төсөв батлагдаагүй, төлөвлөлтийн шаардлага хангаж боловсруулаагүй байна. Үүнд:

- Наран сумын төрийн албан хаагчдад зориулсан орон сууц барихад 500.0 сая;
- Түмэнцогт суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулахад 500.0 сая;
- Мөнххаан суманд нийтийн халуун усны барилга барихад 500.0 сая төгрөгийг тус тус төлөвлөжээ;

3.1.2.9 Их засварын зардлын зориулалтад хамаарахгүй дараах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Аймгийн төвийн авто замын засвар, нөхөөс хийхэд 50.0 сая,
- Эко-1 хорооллын хөрсний ус шавхан зайлуулахад 42.6 сая төгрөг зарцуулахаар тусгасан байна.

3.1.2.10 Мөн Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 107.0 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэсэн Баруун-Урт сумын 4-р цэцэрлэгийн дулаан шугамын засварын ажлыг шинээр хэрэгжүүлэхээр тусган төлөвлөсөн байна. Иймд дээрх 199.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчилж, хөтөлбөр арга хэмжээний зөв ангилалд төлөвлөх шаардлагатай байна.

3.1.2.11 Зураг төсөв, ТЭЗҮ-гүй, магадлалаар баталгаажаагүй, техникийн нөхцөл, зөвшөөрөл аваагүй, зардлын зориулалтад хамааралгүй төсөл арга хэмжээг төлөвлөж байгаа нь Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйл³⁴, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1³⁵, Төрийн хэмнэлтийн

³⁴ Аймгийн чиг үүрэг

³⁵ орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.

тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2³⁶, 13.3.3³⁷, хууль, ЗГ-ын 445 тоот тогтоолыг зөрчиж байгаад албан шаардлага хүргүүллээ.

3.1.2.12 Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг УИХ-аар 306.5 сая төгрөгөөр баталсан боловч БОАЖГ-аас 477.6 сая төгрөгийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Уг арга хэмжээний зардлаар санхүүжих хөрөнгө оруулалтыг 306.5 сая төгрөгт багтаан дахин төлөвлөх нь шаардлагатай байна.

Өмнөх онуудад худалдан авсан болон барьж байгуулсан зарим хөрөнгө зориулалтын дагуу ашиглагдахгүй байна.

3.1.3.1 Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр 2019-2023 онд 1,025 төсөл, арга хэмжээг 44,462.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэл 75.4 хувьтай хэрэгжиж байна.

3.1.3.4 Аудитад 7 сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг 2019-2023 оны байдлаар түүвэрлэн авч олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарч байна. Үүнд:

- Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн аюулгүй байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор камержуулах 13 төсөл арга хэмжээнд 600.0 сая;
- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх 22 төсөлд 605.2 сая;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэцэрлэгжүүлэх 19 төсөлд 604.1 сая;
- Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, боловсролын салбарын материаллаг бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор 38 төсөлд 1,149.5 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна.

3.1.3.5 Харин ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдан авсан, барьж байгуулсан нэн тэргүүнд шаардлагагүй, одоогоор ашиглагдахгүй хөрөнгө байгаа хөрөнгийн талаар дурдвал.

- Дарьганга суманд 40.0 сая өртгөөр баригдсан хуурай сүүний үйлдвэрийн барилга, 10.0 сая төгрөгийн өртгөөр хийгдсэн сумын төвийн хашлага хамгаалалт зэрэг нь зориулалтын дагуу ашиглагдахгүй байна.
- Аймгийн ОНХС-ийн 400.0 сая төгрөгөөр худалдан авсан чулууны үйлдвэр огт ашиглагдахгүй;
- Сумдад Зах зээл ба удирдлагын хөгжлийн төсөл хөтөлбөрийн хүрээнд ОНХС-аас хөрөнгө гаргаж бод малын ангилалтын зогсоол худалдан авсан боловч одоогоор ашиглагдахгүй байна;

3.1.3.6 Иймд ашиглагдахгүй байгаа, хөрөнгийг худалдан борлуулж, орлогыг орон нутагт нэн тэргүүнд шаардлагатай бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулах зүйтэй байна.

³⁶ хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

³⁷ техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

3.2 Аудитаар өгсөн зөвлөмж 86.1 хувьтай хэрэгжсэн бол, төсвийн орлого нэмэгдүүлэх, зардлын үр ашгийг дээшлүүлэх саналын 85.9 хувийг төсвийн төсөлд тусгасан байна.

Өмнөх онд орлого нэмэгдүүлэх, зардлын үр ашгийг дээшлүүлэх саналыг төсвийн төсөлд тусгасан байна.

3.2.1.1 Өмнөх онуудад орон нутгийн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар тооцоо судалгаа, нотлох баримтад тулгуурлан дараах санал, шийдвэрийг шат, шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Үүнд:

3.2.1.2 **2023 он:** Аудитаар хийгдсэн дүн шинжилгээний тооцоололд үндэслэн аймаг, сумын татварын орлогыг 4,190.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, төсвийн урсгал зардлыг 512.9 сая төгрөгөөр бууруулах, зардлын үр ашгийг дээшлүүлэх, ТЭЗҮ, зураг төсөв батлагдаагүй хөрөнгө оруулалтыг төлөвлөхгүй байх, Төрийн хэмнэлтийн болон бусад хууль тогтоомжийг баримтлан ажиллах саналыг шат шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн саналын хэрэгжилт дараах байдалтай байна.

1. Аймгийн татварын орлогыг нэмэгдүүлэх 2,887.1 сая төгрөгийн санал хүргүүлснээс, төсвийн төсөлд 69.2 хувь буюу 2,000.0 сая төгрөгийг нэмж төлөвлөсөн.
2. Сумын татварын орлогыг нэмэгдүүлэх 1,303.6 сая төгрөгийг саналыг хүргүүлснээс 88.5 хувь буюу 1,154.8 сая төгрөгийг хүлээн зөвшөөрч төсвийн төсөлд тусгасан байна.
3. Төсвийн урсгал зардлыг бууруулах 512.9 сая төгрөгийн саналаас 80.5 хувь буюу 412.9 сая төгрөгийн саналыг хүлээн авч төсвийн төслөөс хасаж тооцсон байна.
4. Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцээгүй, орон нутгийн чиг үүрэгт хамааралгүй 5 арга хэмжээг 76.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөснийг хасах санал хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Харин зураг төсөв, ТЭЗҮ батлагдаагүй арга хэмжээг төлөвлөхгүй байх саналыг хэрэгжүүлээгүй байна.

3.2.1.4 Мөн үл хөдлөх албан татвар, албан тушаалын давхардал, орон нутгийн чиг үүрэгт хамааралгүй орон тоонд хүн авч ажиллуулсан, төсвийн байгууллагын халаалтын талбайн хэмжээг буруу тооцож төлбөр нэхэмжилсэн зэрэг зөрчилтэй холбогдуулан төсвийн байгууллага, ОНӨААТҮГ-уудад зөрчил арилгах албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.2.1.5 Орон нутгийн удирдлага хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг батлахдаа жил бүр Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж зураг төсөв, ТЭЗҮ, байгаль орчинд нөлөөлөх үнэлгээг хийлгээгүй арга хэмжээг тусган батлуулж байгаад анхаарал хандуулж хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

Нэг. Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн аймгийн татварын орлого 457.8 сая, сумын татварын орлого 571.0 сая, татварын бааз суурийг нэмэгдүүлснээр жилд дунджаар 361.5 төгрөгөөр татварын орлогыг нэмэгдүүлэх боломжтойг зөвлөж байна. Үүнд:
Аймгийн татварын орлоготой холбоотой

- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр: Уг татварын орлогыг 2024 оны төсвийн төсөлд 600.0 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Цайрт минерал ХХК-ий таван жилийн дундаж зарцуулалт, бусад уул уурхайн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан болон, хөрсний ус шавхан зайлуулах сав газрын дүгнэлт, төлбөр төлсөн байдал зэрэгт үндэслэн тооцож үзэхэд 371.3 сая төгрөгөөр нэмэгдэх боломж байна.
- АТӨЯХАТ: Уг татварын 2023 оны гүйцэтгэлээс харахад 611.3 сая төгрөг төвлөрчээ. Мөн 2023 оны 9 сарын байдлаар 1,159 тээврийн хэрэгсэл шинээр

нэмэгдсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор 15.0 сая төгрөгийн орлого нэмэгдэх боломжтой байна.

- Зам ашигласны төлбөр: 2023 оны 10 сарын байдлаар зам ашигласны төлбөр хураамжаас 45.7 сая төгрөгийн орлого төвлөрчээ. Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-т авто зам ашигласны төлбөрийн хэмжээг аймгийн ИТХ-аар тогтоохоор заажээ. Аймгийн ИТХ-ын „, тогтоолоор баталсан төлбөрийн хэмжээ, 2023 онд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто тээврийн хэрэгслийн тоо зэрэгт үндэслэн зам ашигласны төлбөрийн хэмжээг тооцож үзэхэд 71.4 сая төгрөг төвлөрөх боломжтой байна.

Сумын татварын орлоготой холбоотой

- Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар: Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг 10-20 хувиар, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэх шийдвэр, төрийн албан хаагчийн тоо, дундаж цалин, нэмэгдэл зэрэгтэй уялдуулан тооцож үзэхэд 571.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна.

Татварын бааз суурь, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой

- Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр: Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.21, 39 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлснээр орон нутгийн төсөвт дунджаар 220.0 сая төгрөг төвлөрөх боломжтой байна.
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар: Улсын бүртгэлийн хэлтэст 2020-2023 онд үйлдвэр, үйлчилгээ зориулалтаар бүртгүүлсэн судалгаа, үнэлгээнд үндэслэн тооцож үзэхэд уг татварын орлого 142.1 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна.

Хоёр. Төсвийн урсгал зардлыг 628.6 сая төгрөгөөр хэмнэж, дутагдаж байгаа бусад эх үүсвэрт батлах болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломжтой байна.

- Аймгийн ИТХ-ын даргын нөөц сангийн зарцуулалтад 120.0 сая төгрөгийг төлөвлөсөн бөгөөд нөөц сан зарцуулах журам нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-тай ижил байна. Мөн Захиргааны хэм хэмжээний акт нь улсын бүртгэлд бүртгэснээр хүчин төгөлдөр болох бөгөөд хуулийн хүчин төгөлдөр бус хэм хэмжээний актаар төсөв захиран зарцуулж байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4³⁸ дэх, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5³⁹-т заасантай нийцэхгүй байна. Иймд нөөц санд зарцуулахаар төлөвлөсөн дээрх хөрөнгийг хасаж тооцох нь зүйтэй байна.
- Арбитрын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 680 дугаар шийдвэрээр орон нутгийн төсвөөс "Ум Тэнгэр Трейд" ХХК-д 668.8 сая төгрөгийг олгох шийдвэр гарсан бөгөөд 2023 онд төсвөөс 273.5 сая, орон нутгаас олгосон хөнгөлөлттэй зээлийн төлбөрийн үлдэгдлээс 245.3 сая төгрөгийн өр төлбөрийг чөлөөлсөн байна. Гэтэл төсвийн төсөлд төсвөөс 395.3 сая төгрөгийг төлөхөөр төлөвлөжээ. Иймд тус компанид олгохоор илүү тооцсон 237.3 сая төгрөгийг хасаж, 158.0 сая төгрөг төлөхөөр төсвийн төсөлд тусгах нь зүйтэй байна.
- Цалингийн зардлын тооцоонд давтан тооцоолол хийж, бүтэц орон тоог хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөсөн зэрэгт дүн шинжилгээ хийж үзэхэд цалин, нэмэгдэл урамшууллын зардлыг 265.7 сая төгрөгөөр бууруулах саналтай байна.

³⁸ Захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ.

³⁹ бусад тусгай сангийн үйл ажиллагаатай давхардаагүй байх;

Гурав. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зардлаас дараах төсөл арга хэмжээг хуульд нийцүүлсэн бусад төсөл арга хэмжээг санхүүжүүлэх боломжтой байна.

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтээр зураг төсөв батлагдаагүй, ТЭЗҮ-гүй, аймгийн чиг үүрэгт хамааралгүй 1,500.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- Их засварын зардлын зориулалтад хамааралгүй 3 төсөл арга хэмжээг 199.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг УИХ-аас баталсан хэмжээнээс 170.5 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан ТЭЗҮ, зураг төсөв нь боловсрогдоогүй төсөл арга хэмжээг хуульд нийцүүлэн төсөвлөж, өргөн мэдүүлэх;
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хандив тусламж авахдаа хуульд заасны дагуу "Төр, захиргааны байгууллагатай хамтран ажиллах" гэрээнд тусгаж хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулж, орлогыг бүрэн төвлөрүүлэх;
3. Арбитрын шүүхийн шийдвэрээр төсвөөс хохирол барагдуулсан төлбөрийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулах;

Төрийн санд:

1. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх санал, судалгааг төсвийн төлөвлөлтөд тусгах ажлыг зохион байгуулж, хариу мэдэгдэх;
2. Орлогын гүйцэтгэлд тогтмол дүн шинжилгээ хийж, тасрах эрсдэлтэй татварын болон татварыг бус орлогыг бүрдүүлэх ажлыг цаг тухай бүр зохион байгуулж, төлөвлөсөн зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх;

Татварын хэлтэст:

- Улсын бүртгэлд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар бүртгүүлсэн үл хөдлөх хөрөнгийн судалгаанд дүн шинжилгээ хийж хуульд заасан хувь хэмжээгээр татвар ногдуулах ажлыг зохион байгуулах;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу малын гарал үүслийн тодорхойлолтын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх талаар МЭЕГ, аймгийн МЭГ-тай хамтран, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газарт:

1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахтай холбоотой гарсан шийдвэрийн дагуу тэмдэгтийн хураамжийг ногдуулж төсөвт төвлөрүүлэх;